

Амьтны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, хууль бусаар ан амьтан агнах зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай (зөвлөмж)

2015.05.07

Төрийн захиргааны төв байгууллагаас тухайн жилд амьтан агнах, барихаар тогтоосон дээд хэмжээнд багтаан иргэн, аж ахуйн нэгжүүд зөвшөөрөл авахгүйгээр амьтан агнаж, барих, амьтдын амьдралын онцлогийг харгалзан хуулиар агнах, ашиглахыг хориглосон хугацаанд хууль бусаар ан амьтан агнах, барих зөрчил гаргаж эрүүгийн болон захиргааны хариуцлага хүлээх, ан, агнуурын нөөцөд сөрөг нөлөө үзүүлэхээс урьдчилан сэргийлж Амьтны тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэхийг Мэргэжлийн хяналтын ерөнхий газар зөвлөж байна.

НЭГ.Агнуурын амьтан агнах, агнах болон барихыг хориглох хугацаа

Монгол Улсын Амьтны тухай хуулийн 9 дүгээр зүйлд бор гөрөөс, цагаан зээрийг 12 дугаар сарын 1-ний өдрөөс дараа оны 8 дугаар сарын 31-ний өдөр хүртэл, дархадын цагаан, Буйр нуурын загас, омель, зарам, алтай сугас загаснаас бусад загасыг жил бүрийн 4 дүгээр сарын 1-ний өдрөөс 6 дугаар сарын 15-ны өдөр хүртэл агнах, барихыг хориглоно.

Бор гөрөөс – *Capreoluspygargus*



Зөвшөөрөл:

БОНХ-ийн сайдын тушаалаар тогтоосон тухайн жилийн хяналтын тоонд багтааж энэ хуулийн 25 дугаар зүйлийн 25.1-д зааснаар ахуйн зориулалтаар иргэнд эрхийн бичгээр, тухайн нутгийн сум, дүүргийн Засаг даргатай байгуулсан гэрээгээр анчны үнэмлэхтэй иргэн, хуулийн этгээдэд үйлдвэрлэлийн зориулалтаар бор гөрөөс агнах, барих тусгай зөвшөөрөл олгоно.

Төлбөр хураамж:

Иргэн, хуулийн этгээд энэ хуулийн 32 дугаар зүйлийн 32.1 болон Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.2 мөн 17.1.5-д зааснаар Засгийн газрын 2011 оны 23 тоот тогтоолоор батлагдсан “Агнуурын нөөц ашигласны төлбөр, ан амьтан агнах, барих зөвшөөрлийн хураамжийн хувь хэмжээ”-г баримталсан нэг толгой бор гөрөөсний гур-66000, зүр-80000 төгрөгийг үйлдвэрлэлийн бус зориулалтаар агнахад тус бүрд нь орон нутгийн төсвийн орлогын дансанд урьдчилан тушаах ба харин гадаадын иргэнд тусгай төлбөртэйгээр агнуулахдаа нэг толгой олзворын жишиг үнэ 600, төлбөр 400, хураамж-150 тус тусам долларыг нэмж урьдчилан тушаана.

Зөрчилд хүлээлгэх хариуцлага: Хуульд заасны дагуу зөвшөөрөл авалгүйгээр бор гөрөөс агнасан иргэн, хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхгүйгээр бол байгаль орчны хяналтын улсын байцаагч дор дурдсан захиргааны хариуцлага ногдуулна.

37 дугаар зүйлийн 37.2 дахь заалтаар:

Төлбөр төлж тусгай зөвшөөрөл авалгүйгээр бор гөрөөс агнасан, барьсан гэм буруутай этгээдэд нөхөн төлбөрийн хэмжээг Засгийн газрын 2011 оны 23 тоот тогтоолоор баталсан “Ан амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ”-гээр:

Гурыг-330000 төгрөгөөр

Зүрийг-400000 төгрөгөөр

Эр янзагыг-231000 төгрөгөөр

Эм янзагыг-280000 төгрөгөөр тус тус үнэлж байгаль орчны хяналтын улсын байцаагчийн актаар уг үнэлгээг хоёр дахин өсгөн нөхөн төлүүлэх,

Цагаан зээр –*Pricarpagutturosa*



Зөвшөөрөл :

БОНХ-ийн сайдын тушаалаар тогтоосон тухайн жилийн хяналтын тоонд багтааж энэ хуулийн 25 дугаар зүйлийн 25.1-д зааснаар ахуйн зориулалтаар иргэнд эрхийн бичгээр, тухайн нутгийн сум , дүүргийн ЗД-тай байгуулсан гэрээгээр анчны үнэмлэхтэй иргэн, хуулийн этгээдэд үйлдвэрлэлийн зориулалтаар цагаан зээр агнах, барих тусгай зөвшөөрөл олгоно.

Төлбөр хураамж :

Иргэн , хуулийн этгээд энэ хуулийн 32 дугаар зүйлийн 32.1 болон Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.2 мөн 17.1.5-д зааснаар Засгийн газрын 2011 оны 23 тоот тогтоолоор батлагдсан “Агнуурын нөөц ашигласны төлбөр, ан амьтан агнах, барих зөвшөөрлийн хураамжийн хувь хэмжээ”-г баримталсан нэг толгой цагаан зээрийн ооно-100000 , шаргачин-110000 тус тус төгрөгийг бүх зориулалтаар агнахад тус бүрд нь орон нутгийн төсвийн орлогын дансанд урьдчилан тушаах ба харин гадаадын иргэнд тусгай төлбөртэйгээр агнуулахдаа нэг толгой олзворын жишиг үнэ-200, төлбөр-130 , хураамж-50 ам долларыг нэмж урьдчилан тушаана.

Зөрчилд хүлээлгэх хариуцлага: Хуульд заасны дагуу зөвшөөрөл авалгүйгээр цагаан зээр агнасан иргэн хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол байгаль орчны хяналтын улсын байцаагч дор дурдсан захиргааны хариуцлага ногдуулна. Үүнд:

37 дугаар зүйлийн 37.2 дахь заалтаар:

Төлбөр төлж тусгай зөвшөөрөл авалгүйгээр цагаан зээр агнасан, барьсан гэм буруутай этгээдэд нөхөн төлбөрийн хэмжээг Засгийн газрын 2011 оны 23 тоот тогтоолоор баталсан “Ан амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ”-гээр:

Ооныг-500000 төгрөгөөр

Шаргачинг- 550000 төгрөгөөр

Эр янзагыг-350000 төгрөгөөр

Эм янзагыг – 385000 төгрөгөөр тус тус үнэлж байгаль орчны хяналтын улсын байцаагчийн актаар уг үнэлгээг хоёр дахин өсгөн нөхөн төлүүлэх,

Дархадын цагаан –Coregonuslavaretus



Зөвшөөрөл :

БОНХ-ийн сайдын тушаалаар тогтоосон тухайн жилийн хяналтын тоонд багтааж энэхүү хуулийн 25 дугаар зүйлийн 25.1-д зааснаар ахуйн зориулалтаар иргэнд эрхийн бичгээр, тухайн нутгийн сум, дүүргийн Засаг даргатай байгуулсан гэрээгээр анчны үнэмлэхтэй иргэн, хуулийн этгээдэд дархадын цагаан загас барих тусгай зөвшөөрөл олгоно.

Төлбөр хураамж:


Иргэн, хуулийн этгээд энэ хуулийн 32 дугаар зүйлийн 32.1 болон Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.1 мөн 17.1.5-д зааснаар Засгийн газрын 2006 оны 280 тоот тогтоолоор батлагдсан “Төлбөр хураамжийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай”-г баримтлан дархадын цагаан загасны төлбөрийг нэг килограмм тутам-1000, загас барих нэг удаагийн эрхийн бичиг-10000 төгрөгийг орон нутгийн төсвийн орлогын дансанд урьдчилан тушаах ба харин гадаадын иргэнд тусгай төлбөртэйгээр бариулахдаа нэг олзворын жишиг үнэ 20, төлбөр-10, хураамж-5 ам.долларыг урьдчилан төлнө.

Зөрчилд хүлээлгэх хариуцлага: Хуульд заасны дагуу зөвшөөрөл авалгүйгээр дархадын цагаан загас барьсан иргэн, хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол байгаль орчны хяналтын улсын байцаагч дор дурдсан захиргааны хариуцлага ногдуулна.

37 дугаар зүйлийн 37.2 дахь заалтаар: Төлбөр төлж тусгай зөвшөөрөл авалгүйгээр цагаан зээр агнасан, барьсан гэм буруутай этгээдэд нөхөн төлбөрийн хэмжээг Засгийн газрын 2011 оны 23 тоот тогтоолоор баталсан “Ан амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ”-гээр:

Дархадын цагаан загасыг-20000 төгрөгөөр үнэлж байгаль орчны хяналтын улсын байцаагчийн актаар уг үнэлгээг хоёр дахин өсгөн нөхөн төлүүлэх

Булуу цагаан-Cyprinusrubrofuscus



Зөвшөөрөл :

БОНХ-ийн сайдын тушаалаар тогтоосон тухайн жилийн хяналтын тоонд багтааж энэхүү хуулийн 25 дугаар зүйлийн 25.1-д зааснаар ахуйн зориулалтаар иргэнд эрхийн бичгээр, тухайн нутгийн сум, дүүргийн Засаг даргатай байгуулсан гэрээгээр анчны үнэмлэхтэй иргэн, хуулийн этгээдэд булуу цагаан загас барих тусгай зөвшөөрөл олгоно.

Төлбөр хураамж :

Иргэн, хуулийн этгээд энэ хуулийн 32 дугаар зүйлийн 32.1 болон Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.1 мөн 17.1.5-д зааснаар Засгийн газрын 2006 оны 280 тоот тогтоолоор батлагдсан “Төлбөр хураамжийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай”-г баримталан булуу цагаан загасны төлбөрийг нэг килограмм тутам-1000, загас барих нэг удаагийн эрхийн бичиг-10000 төгрөгийг орон нутгийн төсвийн орлогын дансанд урьдчилан тушаах ба харин гадаадын иргэнд тусгай төлбөртэйгээр бариулахдаа нэг олзворын жишиг үнэ 20, төлбөр-10, хураамж-5 ам.долларыг урьдчилан төлнө.

Зөрчилд хүлээлгэх хариуцлага: Хуульд заасны дагуу зөвшөөрөл авалгүйгээр дархадын цагаан загас барьсан иргэн, хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол байгаль орчны хяналтын улсын байцаагч дор дурдсан захиргааны хариуцлага ногдуулна.

Үүнд :

37 дугаар зүйлийн 37.2 дахь заалтаар: Төлбөр төлж тусгай зөвшөөрөл авалгүйгээр цагаан зээр агнасан, барьсан гэм буруутай этгээдэд нөхөн төлбөрийн хэмжээг Засгийн газрын 2011 оны 23 тоот тогтоолоор баталсан “Ан амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ”-гээр Булуу цагаан загасыг-19000 төгрөгөөр үнэлж байгаль орчны хяналтын улсын байцаагчийн актаар уг үнэлгээг хоёр дахин өсгөн нөхөн төлүүлэх

39 дүгээр зүйл . Хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага

39.1.1. Хугацаа дууссан зөвшөөрлөөр амьтан ашигласан, эсхүл зөвшөөрлийг бусдад шилжүүлсэн, зохих зөвшөөрөлгүйгээр амьтан ашиглахыг завдсан иргэнийг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хоёр дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хөдөлмөрийн доод хэмжээг тав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр тус тус торгох;

39.1.7. Энэ хуулийн 9 дүгээр зүйлд заасан хугацааг зөрчиж ан агнасан, загас барьсан, эсхүл агнуурын амьтныг зохих гэрээ, тусгай зөвшөөрөл, эрхийн бичигт зааснаас хэтрүүлэн агнасан, барьсан иргэнийг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хоёр дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр тус тус торгох;

39.1.9. Зохих эрхийн бичиг, тусгай зөвшөөрөлгүйгээр ахуйн болон тусгай зориулалтаар агнуурын амьтан агнасан, барьсан, энэ хуулийн 26.3-т заасан ан амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эдийн зүйлийг дагалдах тодорхойлолтгүйгээр худалдсан, худалдан авсан бол хурааж, иргэнийг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хоёр дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хөдөлмөрийн хөлсний

доод хэмжээг тав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр тус тус торгох заалттай тул хууль бусаар ан амьтны гаралтай түүхий эд, зүйл худалдан авах, худалдахаас урьдчилан сэргийлж хуулийн хүрээнд ажиллаж нь зүйтэй байна.

Дээрх зөвлөмжийн дагуу хуулийн хэрэгжилтийг хангуулахад анхаарч хамтран ажиллахыг хүсье.

Амьтны тухай хуулийн 12.1-т зааснаар тодорхойлолт аваагүй амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эдийг худалдах, худалдан авахыг хориглоно.



БАЙГАЛЬ ОРЧИН, ГЕОЛОГИ, УУЛ УУРХАЙН ХЯНАЛТЫН ГАЗАР